

Сэлэнхуудан
З.З.Бал-Г

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлд:


"ХХIX.1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн цэнхэр, ягаан тасалбараар хийгдсэн өмч хувьчлалын талаар хийсэн Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтнуудад даалгав:

1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн мэдээллийн санд бүртгэгдсэн 103948 иргэдийн дансны мэдээллийг тулган баталгаажуулах, 2,4 тэрбум төгрөгийг иргэдэд олгох ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Байгальмаа нарт;

2. Төрөөс төрийн өмчийн талаар болон өмч хувьчлал, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг тодорхой болгох, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын болон олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн боловсруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т;

3. Өмч хувьчлалын 1991-1996 оны нэгдсэн мэдээлэл, судалгааг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Архивын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт;

4. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид шилжсэн хөрөнгийн өнөөгийн байдал, орон нутгийн өмч хувьчлалын талаарх судалгааг гарган, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

